



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 16 -ны өдөр

Дугаар А/19

Эрхэлт

**Г Сар шинийн баярын үеийн эмнэлгийн
тусламжийн бэлэн байдлыг хангах, хариуцлагатай жижүүр
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6, 109 дүгээр зүйлийн 109.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны "Журам батлах тухай" А/36, 2019 оны "Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай" А/611 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн газраас сар шинийн баярын үеэр ажиллах хариуцлагатай жижүүрийг хуваарь, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дуудагдан ажиллах албан хаагчийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Сар шинийн баярын өдрүүдээр эмнэлгүүд, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг бүх шатны захирал, дарга нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэдээлэх бүртгэх" АМ-36, "Осол гэмлтийн тохиолдлыг бүртгэх хуудас" АМ-33 маягтын дагуу мэдээг эрүүл мэндийн байгууллагуудаас нэгтгэж Эрүүл мэндийн хөгжлийн төвд хугацаанд нь мэдээллж ажиллахыг эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн (Г.Итгэл)-д үүрэг болгосугай.
4. Хоолны хордлого, архины хордлого, осол гэмтэл, түлэгдэлт, хөдөлтөөс сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн боловсрол, сургалт

сурталчилгаа, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Ганчимэг)-т даалгасугай.

5. Хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдад илүү цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бодож олгохыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)- болон байгууллагын дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 02 сарын 06 өдрийн
14 дугаар тушаалын хавсралт

5043448 3020030036

САР ШИНИЙН БАЯРЫН ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН НЭРС,
ХУВААРЬ

| Д/Д | Албан хаагчийн овог нэр | Албан тушаал | Жижүүр хийх өдөр | Харилцах утасны дугаар |
|--|-------------------------|--|---------------------------|------------------------|
| 1 | Б.Уртнасан | Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн | 02 сарын 21 | 99950350 |
| 2 | Х.Оюун-эрдэнэ | Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, байгууллагуудын үйл ажиллагааны автоматжуулалт хариуцсан мэргэжилтэн | 02 сарын 23 | 99856916 |
| 3 | Д.Отгондэлгэр | Эдийн засагч | 02 сарын 22 | 99017763 |
| 4 | Г.Итгэл | Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн | 02 сарын 21-23-ны хооронд | 99967763 |
| НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕД ДУУДАГДАН АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧИЙН НЭРС | | | | |
| 1 | Д.Лхагважав | Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч | 02 сарын 21-23-ны хооронд | 99559380 |
| 2 | С.Дулмааюмлаа | Бэлгийн замаар дамжих халдвар, хүний хомсдолын вирусын болон гэдэсний халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн | | 99553380 |
| 3 | Б.Билгүүнээ | Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн | | 99365132 |